



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 31 өдөр

Дугаар A/1393

Улаанбаатар хот

### Г Зөвлөгөөн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх зорилтын хүрээнд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгжүүдийн дунд зохион байгуулахад "Хотын стандартын нэгдсэн зөвлөгөө"-ний удирдамжийг 1 дүгээр, зохион байгуулахад шаардагдах зардлын задаргааг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хотын стандартын нэгдсэн зөвлөгөөнийг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор өндөр түвшинд зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү), Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газар (С.Төмөрдуулам)-т тус тус үүрэг болгосугай.

3. Зөвлөгөөнийг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдэж эхэлсэн 38 хотын стандартыг нийтэд таниулж сурталчлахыг Нийслэлийн Сургалт, судалгаа, олон нийттэй харилцах газар (Г.Хонгорзул)-т даалгасугай.

4. Зөвлөгөөнийг зохион байгуулахад шаардагдах, хавсралтад заасан 191,808,750 (нэг зуун ерэн нэгэн сая найман зуун найман мянга долоон зуун тавь) төгрөгийг Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газрын 2022 оны батлагдсан төсвөөс гаргахыг тус газрын дарга С.Төмөрдууламд, хянан санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т тус тус зөвшөөрсүгэй.

5. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсурэнд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Д.СҮМЬЯАБАЗАР



111020006396



Нийслэлийн Засаг даргын 2022 оны  
10.07.2022... сарын 31..ны өдрийн  
11.07.2022 дугаар... захирамжийн  
1 дүгээр хавсралт

## ХОТЫН СТАНДАРТЫН НЭГДСЭН ЗӨВЛӨГӨӨНИЙ УДИРДАМЖ

Нэг.Зорилго

Хотын стандартын талаар төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуй нэгж, иргэд, олон нийтийн түвшинд нэгдмэл ойлголтыг төлөвшүүлэх, стандартын хэрэгжилтийг хянах үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх, тэдгээрийн оролцоог хэрхэн хангах талаар талаар мэдээлэл өгч хотын стандартын тогтолцоог хөгжүүлэхэд шаардлагатай бүх нийтийн оролцоо, харилцан хамтын ажиллагааны суурь нөхцөлийг сурталчлан таниулахад энэхүү хотын стандартын нэгдсэн зөвлөгөөний зорилго оршино.

Хоёр.Зөвлөгөөний агуулга, хамрах хүрээ

Хотын стандартын нэгдсэн зөвлөгөөнийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 18-26 дугаар тогтоолуудаар батлагдсан 9 бүлгийн 38 хотын стандартын бүлэг, сэдвүүдтэй холбоотой дараах 5 удаагийн зөвлөгөөнийг зохион байгуулна.

д/д	Зөвлөгөөний нэр	Агуулга	Оролцогчид
1	Хотын стандартын тогтолцоо	<ul style="list-style-type: none"><li>- Хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх тухай</li><li>- Хотын стандартын танилцуулга</li><li>- Батлагдсан хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээ</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- Монгол Улсын Засгийн газрын гишүүд,</li><li>- МУЗГ-ын холбогдох агентлагийн удирдлагууд /СХЗГ, БХТ, ШӨХТГ/ Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид</li><li>- Хүний эрхийн үндэсний комисс</li><li>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар</li><li>- Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд</li><li>- Холбогдох Нийслэлийн өмчит болон харьяа байгууллагуудын удирдлага</li><li>- Барилга угсралтын болон зураг төслийн компаниуд</li><li>- Мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөлөл Нийт 300 хүртэл хүн оролцох</li></ul>
2	Хотын соёл	<ul style="list-style-type: none"><li>- Хотын стандартын сэдэвчилсэн танилцуулга, /бүтэц, агуулга, ач холбогдол/</li><li>- Хотын соёл ба стандартын харилцан уялдаа</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар</li><li>- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба</li><li>- Нийслэлийн нутгийн захиргааны холбогдох байгууллагууд / НБИХГ, НСҮГ, ННТГ, НАЖГ, НГБХЗХГ, НЦУГ/</li></ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Хотын соёлыг төлөвшүүлэх талаар хэрэгжүүлж буй томоохон ажил</li> <li>- Хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээ, хүлээгдэж буй үр дүн, иргэн, ААН-ийн оролцох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн 9 дүүрэг, 204 хороод;</li> <li>- Их дээд сургуулиуд, оюутны төлөөлөл</li> <li>- Төрийн бус байгууллагууд</li> <li>- СӨХ-ны төлөөлөл</li> </ul> <p>Нийт 1000 хүртэл хүн оролцох</p>
3	Хотын үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>- Хотын стандартын сэдэвчилсэн танилцуулга, /бүтэц, агуулга, ач холбогдол/</li> <li>- Хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээ /нийтийн тээвэр, хог хаягдлын үйлчилгээ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба</li> <li>- Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд /, НАЖГ, ННҮГ, НЗХГ гэх мэт/</li> <li>- Нийслэлийн өмчит харьяа байгууллагууд /ХТГ, ОСНААГ, УСУГ, УБЗЗАГ/</li> <li>- Дүүргүүдийн ЗДТГ, хороод</li> <li>- Холбогдох аж ахуйн нэгж, иргэд</li> <li>- Төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоод</li> </ul> <p>Нийт 500 хүртэл хүн оролцох</p>
4	Иргэдийн ая тухтай орчин	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох хотын стандартуудын танилцуулга</li> <li>- Стандарт, нормын хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ</li> <li>- Иргэдийн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн голлох арга хэмжээ, үр дүн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба</li> <li>- Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд /НЗХГ, ХБХГ, НГЗБА, /</li> <li>- Нийслэлийн өмчит харьяа байгууллагууд</li> <li>- Дүүргүүдийн ЗДТГ, хороод</li> <li>- Холбогдох аж ахуйн нэгж, иргэд</li> <li>- Төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоод</li> </ul> <p>Нийт 1000 хүртэл хүн оролцох</p>
5	Барилгын аюулгүй орчин	<ul style="list-style-type: none"> <li>- Барилгын салбарын норм, стандарт, холбогдох хотын стандартууд</li> <li>- Барилгын орчны хөдөлмөрийн аюулгүй байдал</li> <li>- Барилгын комиссын үйл ажиллагаа</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Барилга хот байгуулалтын яам</li> <li>- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам</li> <li>- Барилгын хөгжлийн төв</li> <li>- Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд /ХБХГ, ХСХГ, НГЗБА, НМХГ/</li> <li>- Нийслэлийн өмчит харьяа байгууллагууд /Хот төлөвлөлт, судалгааны институт/</li> <li>- Төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоод</li> <li>- Барилга угсралтын болон зураг төслийн компани, иргэдийн төлөөлөл</li> </ul> <p>Нийт 300 хүртэл хүн оролцох</p>

Гурав. Удирдлага, зохион байгуулалт

3.1. Хотын стандартын нэгдсэн зөвлөгөөнийг нийслэлийн удирдах албан тушаалтнууд дараах хуваарийн дагуу хариуцан хяналт тавьж удирдан зохион байгуулна.

№	Зөвлөгөөний нэр	Хяналт тавьж албан тушаалтан	Хариуцах байгууллага	Хамтрагч байгууллагууд
1	Хотын стандартын тогтолцоо	Ж.Сандагсүрэн /Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч/		НЗДТГ НССОНХГ
2	Хотын соёл	Д.Мөнх-Эрдэнэ /Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүй, засаглалын асуудал хариуцсан Ахлах зөвлөх/		НЗДТГ, НСУГ, НГБХЗХГ, НЦУГ, НБИХГ, НЦХМТГ
3	Хотын үйлчилгээ	И.Баатархүү /Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга/	Хотын стандарт, хяналтын газар	УБЗАА, ННТГ, ННҮГ, Дүүргүүдийн ЗДТГ
4	Иргэдийн ая тухтай орчин	З.Төмөртөмөө /Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч/		НГЗБА, НССОНХГ НЦХМТГ
5	Барилгын аюулгүй орчин	Ж.Сандагсүрэн /Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч/		ХБХГ, НГЗБА, НССОНХГ

Дөрөв. Бэлтгэл хангуулах арга хэмжээ

Хотын стандартын нэгдсэн зөвлөгөөнийг хүртээмжтэй, үр дүнтэй зохион байгуулахад бэлтгэл арга хэмжээний хүрээнд холбогдох байгууллагууд дараах чиг үүрэгтэй оролцно.

4.1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

- Оролцогчдод нэгдсэн чиглэл өгч мэдээлэл хүргэх;
- Зөвлөгөөний хөтөлбөр, төлөвлөгөөг хянаж, батлуулах;
- Зардлын гүйцэтгэлийг хянаж санхүүжилтийг олгох;

4.2. Хотын стандарт, хяналтын газар

- Зөвлөгөөн бүрийн нарийвчилсан хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах;
- Зөвлөгөөн бүрт оролцогчдын дэлгэрэнгүй жагсаалт гаргаж бүртгэл хөтлөх;
- Нийслэлийн Засаг даргын танилцуулах илтгэлийн агуулга боловсруулах;
- Зөвлөгөөнд оролцогчдод зориулсан танилцуулга, тараах материалыг бэлтгэх;  
/хотын стандартын баримт бичиг, урилга, мандат, тэмдэглэл гэх мэт/
- Хурлын танхимиын зохион байгуулалтыг хариуцах;
- Хэвлэлийн мэдээ бэлтгэх;

4.2. Нийслэлийн сургалт, судалгаа олон нийттэй харилцах газар

- Хотын стандартын 9 бүлэг тус бүрийн талаар шторк бэлтгэх;
- Хэвлэл, мэдээллээр сурталчлах;
- Зөвлөгөөний дүрс бичлэг, фото зураг авах.

#### 4.3. Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар

- Цайны завсарлага бэлтгэх

4.4. Хамtran ажиллах нийслэлийн нутгийн захиргааны болон харьяа байгууллагууд

- Батлагдах төлөвлөгөөний дагуу бэлтгэл хангуулах /ажлын тайлан, мэдээ, танилцуулга, оролцогчдын мэдээлэл/;
- Батлагдсан хотын стандартуудтай сайтар танилцаж, тэдгээрийг мөрдүүлэх талаар зохих арга хэмжээний санал боловсруулсан байх;
- Холбогдох албан хаагчид, хамtran ажилладаг төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоодын оролцоог хангах

Тав.Үр дүнг нэгтгэх, тайлагнах

Хотын стандартын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулсан тухай тайлан, илтгэх хуудсыг зөвлөгөөн бүрээс гарсан зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой санал боловсруулж 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийслэлийн Засаг даргад танилцуулна.

-----o0o-----



Нийслэлийн Засаг Даргын 2022 оны  
сарын 21-ны өдрийн  
захижилн  
2 дугаар хавсралт

ХОТЫН СТАНДАРТЫН НЭГДСЭН ЗӨВЛӨГӨӨНИЙ БЭЛТГЭЛ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ЗАДАРГАА

Д/Д	Зөвлөгөөний нэр сэдэв	Бэлтгэл ажлын задаргаа	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт /төгрөг/
1	Хурлын заал /Блю скай зочид буудал/ Үдийн зоог	Цаг тоо	3 300	800,000.00 77,000.00	2,400,000.00 23,100,000.00	
	Хотын стандартын баримт бичиг хэвлүүлэх /тус бурт 38 хотын стандарт/ Хотын стандартын талаарх контент, шторк	Багц Хуудасны тоо	300 70	241,063.00 100,000.00	72,318,750.00 7,000,000.00	
	Илтгэлийн дизайн хөгжүүлэлт Хөтлөгчийн зардал Мандат Урилга Баннер /стандартэй хамт/ 180*60 см Цаасан тор	Цаг Ш Ш Ш Ш Ш	3 300 300 2 300	300,000.00 3000,00 1500,00 180,000.00 3000,00	900,000.00 900,000.00 450,000.00 360,000.00 900,000.00	
	Дүн					118,728,750.00
2	Хотын соёл	Хурлын заалны төлбөр /Соёлын төв өргөө/ Цайны завсарлага Лед дэлгэцийн төлбөр /5*10 м/ Баннер /180*60 см/ Хөтлөгчийн зардал Мандат	Цаг Хүний тоо Өдөр Ш Цаг Ш	3 1000 1 2 3 1000	1,000,000.00 14,000.00 5,000,000.00 85,000 300,000.00 3000,00	3,000,000.00 10,000,000.00 5,000,000.00 170,000.00 900,000.00 3,000,000.00
	Дүн					22,070,000.00

3	Хотын үйлчилгээ	Хурлын заал, дэлгэцийн төлбөр	Цаг хүний тоо	3 500	700,000.00 14,000.00	2,100,000.00 5,000,000.00
		Цайны завсарлага Хөтлөгчийн зардал	Цаг ш	3 500	300,000.00 3000.00	900,000.00 1,500,000.00
4	Иргэдийн ая тухтай орчин	Мандат	ш	2	85,000	70,000.00
		Баннер /180*60 см/  Дүн				9,570,000.00
5	Барилгын аюулгүй орчин	Хурлын заалны төлбөр /Соёлын төв/ өргөө/	Цаг	3	1,000,000.00	3,000,000.00
		Лед дэлгэцийн төлбөр /5*10 м/ Цайны завсарлага Баннер /180*60 см/ Хөтлөгчийн зардал Мандат  Дүн	Өдөр хүний тоо ш Цаг ш ш	1 1000 2 3 1000	5,000,000.00 14,000.00 85,000 300,000.00 3000.00	5,000,000.00 10,000,000.00 70,000.00 900,000.00 3,000,000.00  21,970,000.00
		Лед дэлгэцийн төлбөр /5*10 м/ Цайны завсарлага Баннер /180*60 см/ Хөтлөгчийн зардал Мандат  Дүн	Өдөр хүний тоо ш Цаг ш ш	1 300 2 3 300 300	5,000,000.00 14,000.00 85,000 300,000.00 3000.00	5,000,000.00 3,000,000.00 70,000.00 900,000.00 9,870,000.00
		Нийт дүн				191,808,750.00